


ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Энэхүү өсөлт нь өнгөрөгч сарын ажил эрхлэлтийн төвшин өндөр байсантай холбоотой юм. Зах зээлийн үнэлгээ өндөр компаниудаас бүрдэх S&P 500 индекс болон технологийн компаниудыг илүү багтаасан Nasdaq индексүүд түүхэн өндөр үзүүлэлтүүдэд хүрлээ. S&P 500 индексийн сагсанд багтах компаниудаас Merck болон Pfizer компаниудын ашигт ажиллагаа хүлээлтээс өндөр байсантай холбоотой эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцаа хамгийн их өсөлттэй байсан бол газрын тосны үнэ унасантай холбоотой эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа уналттай байлаа.

Компаниудын хувьцааны ханшийн өөрчлөлтүүд 3-р улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдээс ихээхэн хамаарсан ба S&P 500 индексийн сагсанд багтах ихэнх компаниудын санхүүгийн үзүүлэлтүүд шинжээчдийн таамгийг давсан ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт компаниудын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд буурсан байна.

Лхагва гарагт зохион байгуулагдсан Холбооны Нөөцийн Сангийн мөнгөний бодлогын уулзалтын үр дүнд, бодлогын хүүг дахин 0.25%-аар бууруулсан ба цаашид хүүг дахин бууруулах эсэхийг эдийн засгийн үзүүлэлтүүдээс хамааран түр азнана гэдгээ илэрхийлжээ. Харин Холбооны Нөөцийн Сангийн Ерөнхийлөгч ноён Жером Пауэлл уулзалтын дараах хэвлэлийн бага хурлаар инфляцын төвшин хүлээлтэд хүрч байвал бодлогын хүүг нэмэх сонирхолгүй хэмээн мэдэгджээ.

Европ: Европын холбооноос Brexit-ийн эцсийн хугацааг 3 сараар хойшлуулсан, БНХАУ-ын үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд эерэг байсан болон бүс нутагт орж ирэх хөрөнгийн урсгал нэмэгдсэнтэй холбоотойгоор Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа.

Европын холбооноос Brexit-ийн эцсийн хугацааг хойшлуулснаас үүдэн Их Британийн Ерөнхий Сайд ноён Борис Жонсоны 12-р сарын 12-ны өдөр сонгууль явуулах санал дэмжигдлээ. Шинжээчдийн үзэж байгаагаар сонгогчид дэмжигч буй нэр дэвшигчээсээ илүү Brexit-ийг амжилттай эцэслэхэд нэмэр болох боломжтой нэр дэвшигчийг сонгох хандлагатай байх тул энэхүү сонгуулийн дүнг урьдчилан таамаглах боломжгүй байгаа юм.

Европын төв банк бодлогын хүүг хэвээр үлдээн хөрөнгө худалдан авах хөтөлбөрөө дахин эхлүүлэх ба сард дунджаар 20 тэрбум еврогийн худалдан авалт хийхээ мэдэгдэв.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байсан ба Nikkei 225 индекс өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 14%-аар өндөр байна.

Японы төв банкнаас мөнгөний бодлогын хүүг хэвээр үлдээх шийдвэр гаргасан байна. Энэхүү шийдвэрийг АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрийн ахиц болон хэлэлцээргүй Brexit-ийн магадлал буурсантай холбоотой юм.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Энэхүү өсөлт нь БНХАУ-ын компаниудын ашигт ажиллагаа өндөр байсантай болон АНУ-тай хийх худалдааны хэлэлцээрийн ахицаас үүдсэн үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотой юм.

10-рсард БНХАУ-ын PMI индекс 51.7 болон өссөн нь шинжээчдийн хүлээлтийг давжээ. Энэхүү индекс нь АНУ-аас гаалийн татвар ногдуулсны дараагаар өссөн нь БНХАУ-ын эдийн засаг сэргэж байгааг илэрхийлж байна. Гэхдээ БНХАУ-ын 10-р сарын үйлдвэрлэлийн бусад үзүүлэлтүүд уналттай байгаа нь АНУ болон БНХАУ-ын худалдааны маргааны асуудлын эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөө байсаар байгааг харуулжээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,331.17	1.13% ▲
Dow Jones	АНУ	27,347.36	1.44% ▲
S&P 500	АНУ	3,066.91	1.47% ▲
Nasdaq	АНУ	8,386.40	1.74% ▲
S&P/TSX	Канад	16,594.07	1.16% ▲
FTSE 100	Их Британи	7,302.42	-0.30% ▼
S&P/ASX 200	Австрали	6,669.10	-1.04% ▼
Nikkei 225	Япон	22,850.77	0.22% ▲
Hang Seng	Хонг Конг	27,100.76	1.63% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.53
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.81
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.80
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.85
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.81
DBM' 2023	USD	7.250%	105.23
TDBM' 2020	USD	9.375%	102.58
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.63

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.774	-0.03 ▼
Libor 3M	1.890	-0.04 ▼
Libor 6M	1.900	-0.03 ▼
Libor 1YR	1.930	-0.03 ▼
US 2YR Bond	1.582	-0.04 ▼
US 3YR Bond	1.577	-0.04 ▼
US 5YR Bond	1.579	-0.05 ▼
US 10YR Bond	1.749	-0.05 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.11.01	Өөрчлөлт
USD	2,701.11	0.56% ▲
CNY	383.69	1.02% ▲
EUR	3,014.71	0.97% ▲
RUB	42.18	0.45% ▲
KRW	2.32	1.31% ▲
JPY	25.02	1.17% ▲
CAD	2,054.15	-0.11% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,514.34	0.65% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	18.13	0.50% ▲
Зэс	USD/lb.	265.30	-0.84% ▼
Нүүрс	USD/MT	69.95	3.32% ▲
WTI газрын тос	USD/bbl.	56.20	-0.81% ▼
Brent газрын тос	USD/bbl.	61.69	-0.53% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. IX	9.00%
Бодлогын хүү	2019. IX	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. IX	11.12%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. IX	11.37%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. IX	4.95%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. IX	16.91%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. IX	10.76%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 45 компанийн 5,233.8 сая төгрөгийн 3,088,342 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Улсын их дэлгүүр” /UID/ компанийн хувьцаа 16.91%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,300.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Стандарт проперти групп” /BBD/ компанийн хувьцаа 14.93%-аар буурч 91.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

11-р сарын 1-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,445.9 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,331.17 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.13%-аар өссөн байна.



Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	5,233.8
Зах зээлийн үнэлгээ	2,445,918.9

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,331.17	1.13% ▲
MSE I индекс	8,512.28	3.17% ▲
MSE II индекс	7,480.01	1.23% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Атар-Өргөө	76,713	4,618,122,600
Ард санхүүгийн нэгдэл	136,615	204,524,854
Ард кредит ББСБ	1,725,740	133,167,610
Говь	183,546	48,692,095
Ард даатгал	583,403	38,433,499

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Улсын их дэлгүүр	1,300.00	16.91% ▲
Дархан гурил тэжээл	2,111.00	14.98% ▲
Хөх ган	72.00	12.50% ▲
Махимпекс	2,499.00	12.16% ▲
МИК Холдинг	12,220.00	11.09% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Стандарт проперти групп	91.00	-14.93% ▼
Тээвэр дархан	7,500.00	-14.77% ▼
Айтүүлс	71.11	-9.87% ▼
Лэндмн ББСБ	42.34	-6.04% ▼
Говь	266.61	-1.98% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Би Ди Сек	9,126,110,479
Ард Секюритиз	660,033,612
Стандарт Инвестмент	162,421,182
Бумбат-Алтай	130,148,080
Голомт Капитал	107,443,320

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	504.95	537,358
Таван толгой	6,550.00	344,957
МИК Холдинг	12,220.00	253,068
Говь	266.61	207,986
Инвескор ББСБ	2,097.00	150,413

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.21-нд олгов
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.18-нд олгов
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.10.24-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Хөрөнгийн зах зээлийг дэмжих сар” аяныг өрнүүлж, арилжааны шимтгэлээ 0.9% болгон буурууллаа

Хөрөнгийн зах зээлийн шилдэг үнэт цаасны компаниудын нэг болох “Ти Ди Би Капитал ҮЦК” нь Монгол улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж эхэлсний 9 жилийн ойгоо угтан, зах зээлийн тогтвортой өсөлтийг дэмжих, олон нийтийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, зах зээлийн идэвхийг сайжруулах зорилгоор 2019 оны 11-р сарыг “ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ДЭМЖИХ САР” болгон зарлалаа.



Энэхүү аяны хүрээнд тус компани нийт харилцагчдынхаа хувьцааны арилжааны шимтгэлийг 3 сарын турш 0.9% болгон бууруулж бэлэг барьж байна. Тус урамшуулалд 2019 оны 11 сард үнэт цаасны дансаа шинээр нээлгэсэн харилцагчид мөн хамрагдах бөгөөд харилцагч нартаа зориулсан хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох сургалтуудад үнэ төлбөргүй хамрагдах боломжтой юм.

Ти Ди Би Капитал ҮЦК нь дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжилд хувь нэмрийг оруулах олон ажлуудыг санаачлан хэрэгжүүлсний нэг нь Монголын хөрөнгийн биржтэй шууд холболт бүхий хамгийн анхны онлайн арилжааны системийг бий болгож, харилцагчиддаа үнэт цаасны арилжаанд хамгийн түргэн шуурхай, цаг хугацааны хоцрогдолгүйгээр оролцох, үнэт цаасны дансаа зайнаас удирдах, мэргэжлийн шинжээчдийн тайлан судалгаатай тогтмол танилцах боломжийг олгосон билээ.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

“Инвескор ББСБ” ХК 2019 оны 3-р улирлын үйл ажиллагааны тайлангаа нийтэлжээ.

Санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг “Инвескор ББСБ” ХК /MSE: INV/ 2019 оны 3-р улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангаа Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд нийтэлжээ.

“Инвескор ББСБ” ХК нь 2019 оны 9-р сарын 30-ны байдлаар 10.8 тэрбум төгрөгийн хүүгийн цэвэр орлого, 5.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Тус компанийн хувьцаа Монголын Хөрөнгийн Биржийн 3-р ангилалд бүртгэлтэй ба 2019 оны 11-р сарын 1-ний өдрийн байдлаар хаалтын ханш 2,097.0 төгрөг байна.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

“Атар-Өргөө” ХК-ийн тендер арилжаа явагдлаа

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.11 дэх заалтад заасан “Компанийн хувьцаа эзэмшигч дангаараа буюу холбогдох этгээдтэй хамтран, эсхүл хувьцаа эзэмшдэггүй этгээд тухайн компанийн хувьцааг бүхэлд нь, эсхүл хувьцааны хяналтын багцаас дээш хувийг худалдан авахаар сайн дурын үндсэн дээр санал гаргана” гэж заасныг удирдлага болгон “Таван Богд Инвест” ХХК нь МХБ-ийн үнэт цаасны 2-р ангилалд бүртгэлтэй “Атар-Өргөө” ХК-ийн 174,136 ширхэг энгийн хувьцааг нэг ширхгийг 60,200 төгрөгөөр худалдан авах санал гаргасан.

Хувьцааг худалдан авах тендер саналыг 2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 13:00 цаг хүртэл авсан бөгөөд “Атар-Өргөө” ХК-ийн 44% буюу 76,713 ширхэг хувьцааны 4,618,122,600 төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

СЗХ компанийн бондын зах зээлийг хөгжүүлэхэд ЖАЙКА-тай хамтран ажиллаж байна

Санхүүгийн зохицуулах хороо “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх II үе шатны төсөл”-ийн хоёрдугаар үе шатыг Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран 2019 оны гуравдугаар сараас хэрэгжүүлж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн төслийн зөвлөхтэй уулзаж компанийн бондын зах зээлийг хөгжүүлэх, бирж бус зах зээлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ярилцлаа.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

“Фронтинер лэнд групп” ХК-аас хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлалаа

2-р ангилалд бүртгэлтэй Фронтинер лэнд групп /MSE:MDR/ компани хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит бус хурлыг ирэх сарын 9-ний өдөр хуралдуулахаар товллоод байна.

Энэ удаагийн хурлаар компанийнхаа үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулах болон цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, хувьцаагаа эргүүлэн худалдан авах зэрэг асуудлуудыг хэлэлцэхээр төлөвлөжээ.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авах асуудлын тухайд тус компанийн 2,095,891 ширхэг хувьцааг эзэмшдэг Би Ди Сек /MSE:BDS/-ээс хувьцаагаа худалдах саналыг компанид ирүүлээд байгаа.

Фронтинер лэнд групп нь одоогоор үл хөдлөх хөрөнгийн менежмент, түрээсийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Улаанбаатар хотод байрлах өөрийн эзэмшлийн оффис, үйлчилгээний талбай, орон сууцыг түрээсэлж байна.

Өнгөрөгч 8 сард ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлагыг өөрчилж, О.Амартүвшинг гүйцэтгэх захирлаар томилсон юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” ХК нь Хэдли Виддап-ыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томиллоо

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци” ХК (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-ийн гишүүнээр Хэдли Виддап (“Hedley Widdup”)-ыг томилж буйг танилцуулаж байна. Ноён Виддап нь Лайон Менежер компани (“Lion Manager Pty”)-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг бөгөөд Эрдэнэ Ресурсийн ТУЗ-ийн хараат бус гишүүний үүрэг гүйцэтгэнэ.

Эрдэнэ Ресурсийн ТУЗ-ийн дарга Лэйтон Крофт: “Бид Хэдлиг Эрдэнэ Ресурсийн ТУЗ-ийн гишүүн болж байгаад баяртай байна. Тэрээр Австралийн томоохон уурхайнуудад геологич, Лайон Селекшн Групп (“Lion Selection Group”)-д хөрөнгө оруулалтын менежерээр 20 гаруй жил ажилласан туршлагатай мэргэжилтэн юм. Хөгжүүлэлтийн шатнаас олборлолтын үйл ажиллагаанд шилжиж буй компаниудтай хамтран ажиллаж байсан түүний уул уурхай болон санхүүгийн салбарын туршлага нь Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтэд чухал хувь нэмэр болно гэж бид итгэж байна.”

Хэдли нь Мт Кэйт Никелийн уурхай (“Mt Keith Nickel Mine, WA”), Олимпик Дам Зэс-Ураны уурхай (“Olympic Dam Copper-Uranium Mine, SA”), Мт Иса уурхайн цогцолбор ба Ст Ивэс алтны уурхай (“Mt Isa Mining complex, Qld” ба “St Ives Gold Mine, WA”)-н нэг хэсэг; Блэк Стар Цайрын ил уурхай (“Black Star Open cut zinc project”)-н геологийн багт ажиллаж байсан. Тэрээр 2007 онд Лайон Селекшн Групп-ийн хөрөнгө оруулалтын багт нэгдэж, хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулагчтай харилцах чиглэлээр ажилласаар ирсэн. Лайон Селекшн Групп нь Австралийн Мельбурн хотод төвтэй, хөгжүүлэлтэд чиглэсэн уул уурхайн хөрөнгө оруулалтын сан бөгөөд энэхүү сан нь сүүлийн жилүүдэд Эрдэнэ Ресурсийн хувьцааг эзэмшиж байна.

Хэдли нь Австрали улсад Мельбурнийн Их Сургуулийг геологич мэргэжлээр, хүндэт дипломтой төгссөн (2000) бөгөөд хэрэглээний санхүүгийн чиглэлээр магистрийн зэрэг хамгаалсан (2011). Тэрээр Лайон-ын хөрөнгө оруулсан Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Иганстрит Ресурсиз (“EganStreet Resources, ASX:EGA”)-ийн хараат бус ТУЗ-ийн гишүүн бөгөөд Лайон Селекшн Групп-д хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Лайон Менежер компанийн гүйцэтгэх захирал ба хувьцаа эзэмшигч юм.

Эх сурвалж: Erdene.com

Монголбанк 12.9 тонн алт худалдан аваад байна

Монголбанк 2019 оны эхний 10 сард 12.9 тонн үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үед 17.8 тонн үнэт металл худалдан авснаас 4.9 тонноор бага буюу 27%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Монголбанк 2019 оны 10-р сард 1.7 тонн үнэт металл худалдан авсан ба үүнээс Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 51.8 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 58.7 кг үнэт металлыг худалдаж авсан нь өмнөх оны мөн үед 3.4 тонн үнэт металл худалдан авч байснаас 1.7 тонноор буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 10-р сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 128,362.91 төгрөг байлаа.

Эх сурвалж: Монголбанк

Ноосны урамшуулал малчдын дансанд орж эхэллээ

Өнгөрсөн онд үндэсний үйлдвэрүүдэд нийлүүлсэн ноосны мөнгөн урамшуулал 10-р сарын 29-ний өдрөөс эхлэн малчдын дансанд орж эхэллээ. Ноосны урамшуулал олгох Засгийн газрын шийдвэрийн дагуу 2011-2017 онд 158 тэрбум төгрөгийг Монголбанкаар дамжуулан олгосон бол энэ удаа урамшуулал Төрийн сангаас шууд малчдын нэрийн дансанд шилжиж байгаа аж.

Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмын шаардлага хангасан үндэсний үйлдвэрүүдэд 11,5 мянган кг хонь, тэмээний ноос бэлтгэж тушаасан 49 мянган малчин, мал бүхий этгээдийн урамшуулалд нийт 13 тэрбум төгрөг олгохоор болжээ.

Хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгох тухай журмыг Монгол Улсын Засгийн газар 2011 онд баталсан. Үүнээс хойш уг журамд гурван удаа нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд энэ онд Мал хамгаалах сангийн ажлын албыг татан буулгаж төсвийн урамшууллыг ХХААХҮЯ-аар дамжуулан олгохоор болсон юм.

Монгол Улсын Засгийн газраас ноосны урамшуулал олгосноор малчдын орлого, үйлдвэрлэлийн хүчин чадал, тоо хэмжээ, нэр төрөл нэмэгдэж 5700 гаруй ажлын байр бий болсон эерэг үзүүлэлтүүд гарчээ.

Эх сурвалж: Montsame.mn

мэдэгдэл

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.